131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,318,884.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,282,451.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Ногооннуур сумын Засаг дарга нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд “хөрөнгө оруулалтыг сумын хөгжилтэй уялдуулах замаар ард түмний санал санаачилгад тулгуурлан хэрэгжүүлснээр нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, аймгийн Загвар сум болгох” гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилтын хүрээнд доорх дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- *Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх*
- *Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулах*
- *Ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах.*
- *Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллах*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2023 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 348.9 сая төгрөгөөр буюу 7.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	<i>/мянган төгрөгөөр/</i>		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	502,777.2	265,905.5	-236,871.7
Авлага	217,019.2	202,985.2	-14,034.0
Урьдчилж гарсан зардал	0	0	0
Бараа материал	67,058.0	86,811.5	19,753.5
Үндсэн хөрөнгө	4,117,171.7	3,999,443.5	-117,728.2
Нийт хөрөнгө	4,904,026.1	4,555,145.7	-348,880.4
Өр төлбөр	56,757.8	43,638.5	-13,119.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,847,268.3	4,511,507.2	-335,761.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,904,026.1	4,555,145.7	-348,880.4

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 265.9 сая төгрөг болж, өмнөх оноос 236.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+),
			Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	502.7	265.9	(236.8)
Төгрөг	502.7	265.9	(236.8)
Төрийн сангийн харилцах	499.3	260.6	(238.7)
Арилжааны банк дахь харилцах	3.4	5.3	1.9
Дүн	502.7	265.9	(236.8)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Оны эцэст Төсвийн ерөнхий орлогын дансанд 86.5 сая төгрөгийн, ОНХС-д 98.7 сая төгрөгийн, Сум хөгжүүлэг сангийн дансанд 75.5 сая төгрөгийн, Эмийн эргэлтийн сан 5.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 202.9 сая төгрөг болж, өмнөх оноос 14.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	0.6	0.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	0.6	0.6
Зээлийн хүүгийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	-	-	-
Хувь хүмүүсээс авах авлага	-	-	-
Зээлийн авлага	217.0	201.7	(15.3)
Хувь хүмүүст олгосон зээл	217.0	201.7	(15.3)
Дүн	217.0	202.9	(14.1)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Ажиллагсадтай холбоотой авлага 0.6 сая төгрөгөөр, төлбөртэй үйлчилгээний авлага 0.6 сая төгрөгөөр нэмэгдэж, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 15.3 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 189,316.8 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэл байгаагаар тайлагнасан ба зээлийн авлагын дэлгэрэнгүй бүртгэлээр 32 иргэнтэй холбоотой 196,356.3 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс 18 иргэнтэй холбоотой 90,615.7 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн хөнгөлөлттэй зээлийн авлагатай байгааг барагдуулах арга хэмжээ аваагүй, үлдэгдэл нь баталгаажаагүй, санхүүгийн тайлан болон зээлийн авлагын дэлгэрэнгүй бүртгэлд тусгагдсан авлагын үлдэгдэл 7,040.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 86.8 сая төгрөг болж, өмнөх оноос 19.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	4.6	14.0	9.4
Эм боох материал	4.6	14.0	9.4
Бэлэн бүтээгдэхүүн	-	-	-
Хангамжийн материал	42.3	52.7	10.4
Бичиг хэргийн материал	-	-	-
Аж ахуйн материал	25.2	30.2	5.0
Сэлбэг хэрэгсэл	-	-	-
Түлш, шатах тослох материал	0.4	5.8	5.4
Хүнсний материал	-	-	-
Бусад хангамжийн материал	16.7	16.7	-
Мал амьтад	20.1	20.1	-
Дүн	67.0	86.8	19.8

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

ЗДТГ 71.5 сая төгрөгийн, ИТХ 1.3 сая төгрөгийн, Эмийн эргэлтийн сан 14.0 сая төгрөгийн нийтдээ 86.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Бусад эргэлтийн хөрөнгө байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,999.4 сая төгрөг болж, өмнөх оноос 117.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,112.0	3,992.5	(119.5)
Барилга, байгууламж, орон сууц	650.1	659.7	9.6
Авто-тээврийн хэрэгсэл	120.8	131.9	11.1
Машин тоног төхөөрөмж(компьютер)	29.5	98.1	68.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	25.3	35.9	10.6

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Зам, гүүрийн байгууламж	3,284.7	3,065.3	(219.4)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	-	-	-
Дуусаагүй барилга, байгууламж	-	-	-
Ном	1.6	1.6	0
Биет бус хөрөнгө	5.2	6.9	1.7
Программ хангамж	-	1.4	1.4
Бусад биет бус хөрөнгө	5.2	5.5	0.3
Дүн	4,117.2	3,999.4	(117.8)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 4.112.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба төсвийн хөрөнгөөр 55.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 267.6 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 23-ны 156 тоот тогтоолоор 117.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж, аймгийн ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 23-ны 156 тоот тогтоолоор 40.0 сая төгрөгийн Ланд-100, аймгийн ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 23-ны 149 тоот тогтоолоор 22.5 сая төгрөгийн Ланд-80, аймгийн ИТХ-ын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны 117 тоот тогтоолоор 20.0 сая төгрөгийн УАЗ-390942017 маркийн фермер авто машиныг аймгийн Төрийн өмчийн газарт, 6.9 сая төгрөгийн УАЗ-469 маркийн авто машиныг Цагдаагийн газарт шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр данс 2023 оны эхэн үлдэгдэлгүй ба оны эцэст 43.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ сая төгрөгөөр /	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	-	43.6	43.6
Ажилчидтай холбогдсон өглөг	-	-	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	-
Бусад өглөг	-	-	-
Байгууллагад төлөх өглөг	-	43.6	43.6
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-
Дүн	-	43.6	43.6

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

ОНХСан 36.5 сая төгрөгийн, Эмийн эргэлтийн сан 7.1 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Өглөг данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,511.5 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 335.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр /

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	837.6	837.9	0.3
Хуримтлагдсан үр дүн	3,124.7	3,673.6	548.9
Өмнөх үеийн үр дүн	8,099.6	3,137.1	(4,962.5)
Тайлант үеийн үр дүн	(4,974.9)	(348.5)	(4,626.4)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	885.0	885.0	0
Дүн	4.847.2	4,511.5	-335.7

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Ногооннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,970.7 сая төгрөгөөр, төсвийн зарлагыг 2,143.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн тодотголоор 173.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2,143.8 сая төгрөгөөр баталсан байна.

Нийт зардлын 1,103.2 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 369.3 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогын санхүүжилтээр, 506.5 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 100.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос 64.8 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ..

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Ногооннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,884.2 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд: улсын төсвөөс 369.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, сумын орон нутгийн төсвөөс 965.7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 506.5 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 42.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 39.7 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын эргэн төлөлтийн орлого, 3.0 сая төгрөг нь ОНХСангийн орлого байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,830.2 сая төгрөг буюу 85.3 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна. Татварын орлого нь төрийн сангийн зарлагын гүйлгээг 12 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгож хааснаар дутуу биелэгдсэн байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2022 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 132 дугаар тогтоолоор Ногооннуур сумын 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 666.4 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын хуралдааны “2023 оны төсөвт тодотгол хийх тухай” 2023 оны 192 дугаар тодотголоор 666.4 сая төгрөгөөр хэвээр нь баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 68 дугаар хуралдааны тогтоолоор 2023 орлогын төлөвлөгөөг 724.1 сая төгрөгөөр 57.7 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 672.3 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 51.9 сая төгрөгөөр буюу 7.2 хувиар тасарсан байна.

<i>Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>			<i>/сая төгрөг/</i>	
<u>Үзүүлэлт</u>	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	<u>Өсөлт/+, бууралт -/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
I.Татварын орлого	716.6	630.5	86.1	88.0
II.Татварын бус орлого	7.5	41.7	-34.2	554.5
Нийт дүн	724.1	672.2	51.9	92.8

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Орон нутгийн татварын орлогод 716.6 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 630.5 сая төгрөг оруулж 86.1 сая төгрөгөөр буюу 12 хувиар тасарсан. Татварын бус орлогод 7.5 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 41.7 сая төгрөг оруулан 34.2 сая төгрөгөөр давуулсан биелүүлсэн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд цалин хөлс түүнтэй адилтгах орлого 106.6 сая, хүүгийн орлого 0.6 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсан орлого 0.1 сая, хөрөнгийн орлого 1.5 сая, ойгоос мод түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр 0.7 сая, хүү торгуулийн орлого 1.7 сая төгрөгөөр давж, төлөвлөгдөөгүй нэр заагдаагүй бусад орлогоос 32.5 сая, малд ногдуулах албан татвараас 9.1 сая төгрөгийн орлого оруулсан нь төлөвлөгөөний биелэлтэд голлон нөлөөлсөн байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 42.4 сая төгрөг олгосон байна.

Үйл ажиллагааны орлогын албан татвар 52.6 сая төгрөгөөр, бууны албан татвар 3.0 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 2.8 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 16.9 сая төгрөгөөр, газрын төлбөр 9.3 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 38.7 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 10.0 сая төгрөгөөр, агнуурын нөөцийн төлбөр 70.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 379.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба 672.7 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, оны эцэст 86.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

<i>/сая төгрөг/</i>				
<u>Д/д</u>	<u>Байгууллагын нэр</u>	<u>Батлагдсан төсөв</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Хэтрэлт, хэмнэлт</u>
1	ИТХурал	213.7	186.8	-26.9
2	ЗДТГазар	1,033.0	936.9	-96.1
3	Ерөнхий боловсролын 1-р сургууль	76.0	75.9	-0.1
4	Ерөнхий боловсролын 2-р сургууль	21.2	17.2	-4.0
5	Ерөнхий боловсролын 3-р сургууль	15.4	15.3	-0.2
6	Ерөнхий боловсролын 4-р сургууль	11.8	11.3	-0.5
7	Хүүхдийн цэцэрлэг	15.2	15.2	-
8	Хүүхдийн цэцэрлэг-2	32.5	23.6	- 8.9
9	Соёлын төв	8.2	7.0	-0.8
10	Эрүүл мэндийн төв	27.1	27.1	-

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

11	ОНХСан	589.8	499.4	-90.4
12	СХСан	100.0	14.2	-85.8
	Нийт дүн	2,143.9	1,830.2	-313.7

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Сумын ЗДТГ, ИТХ-ын төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан төлөвлөлттэй холбоотой байна. ОНХСангийн төсвийн гүйцэтгэлд 5 төсөл хөтөлбөрийн ажил дутуу хийгдсэн нь нөлөөлсөн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд 13.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Үүнд: дээд шатны төсвийн захирагчаас нийт 7.3 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 6.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч тээвэр шатахууны зардалд 2.1 сая, томилолтын зардалд 0.8 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 10.0 сая төгрөг, төвлөрүүлэг шилжүүлэг 0.7 нийт 13.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/42 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 4,904.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 73.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 227.7 сая төгрөгийн 28 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 227.7 сая төгрөгийн 28 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 1,072.4 сая төгрөгийн 18 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

Шилэн данстай холбоотой зөрчил гараагүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа зөрчилтэй суудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	0	0	0	0	0
Нийт дүн	0	0	0	0	0

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар сумын Засаг дарга нарт “Малын татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, орлогыг сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах” талаар зөвлөмж өгөгдсөн байна. Ногооннуур сумын ИТХ-аас малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг батлаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлантай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын 1, 2, 3, 4 дүгээр сургууль, хүүхдийн 1, 2 дугаар цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 159.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 147.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага, 1 заалттай 12.0 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт 4: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сумын ЗДТГазар	2	61.5					1	49.5	1	12.0
2	ХХС	1	97.6					1	97.6		
Нийт дүн		3	159.1					2	147.1	1	12.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								